



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл ажиллагаа  
эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах тухай

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1 дэх хэсэг, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурьдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

3. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Аялал жуулчлал, дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан иргэн, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгосугай.

4. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын дөрөвдүгээр хавсралтад дурьдсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай сунгасугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /С.Туул/-д үүрэг болгосугай.

6. Тушаалын үнэт цаасны бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /П.Ариунаа/-д даалгасугай.

ДАРГА



Э.БАТТУЛГА

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 06 сарын 16 өдрийн  
А/ч. тоот тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2014.06.16

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Голден прогресс трейдинг ХХК	Женекс	Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Чоймболын гудамж, Их тойруу 25
2	Зул Оюу ХХК	Би энд Жи	Баянзүрх дүүрэг, 13-р хороо, ЭТӨЧ 123
3	Оюуны аав ХХК	Агора	Баянзүрх дүүрэг, 16-р хороо, Улаанхуарангийн гудамж 80

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 06 сарын 16 өдрийн  
А/41 тоот тушаалын хоёрдугаар хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ  
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ


2014.06.16

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Дун-Өргөө ХХК	Өргөө	Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жуулчны гудамж м100/6
2	Пума Империал ХХК	Пума Империал	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их сургуулийн гудамж-2
3	Улаанбаатар зочид буудал ХХК	Улаанбаатар	Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын гудамж
4	Блю скай эжиа ХХК	Блю скай	Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-17
5	Асгат жавхлант ХХК	Эрмүүн	Баянгол дүүрэг, 14-р хороо, Л.Энэбишийн өргө чөлөө 19 а
6	Эх хийморь ХХК	Хийморь	Хан-Уул дүүрэг, 2-р хороо, Үйлдвэрчний гудамж 17-1

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 06 сарын 16 өдрийн  
А.М.Т. тоот тушаалын гуравдугаар хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ  
ОЛГОХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖҮҮДИЙН  
ЖАГСААЛТ


2014.06.16

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Отгонбаяр	Бөрт	Сүхбаатар дүүрэг, 10-р хороо, Цагдаагийн гудамж
2	Иргэн Д.Даваацэрэн	Арвай	Сонгинохайрхан дүүрэг, 14-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 28
3	Найс макер ХХК	Найс	Сонгинохайрхан дүүрэг, 19-р хороо, 75/5

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын  
даргын 2014 оны 06 сарын 16 өдрийн  
А/ц тоот тушаалын дөрөвдүгээр хавсралт



ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРЛИЙГ  
СУНГАХ ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН НЭРСИЙН  
ЖАГСААЛТ

2014.06.16

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, Аж ахуйн нэгжийн нэр	Оноосон нэр	Байршил
1	Стар интер трейд ХХК	АСЕ	Баянгол дүүрэг, 7-р хороо, Ард Аюушийн өргөн чөлөө 34
2	ЦПО ХХК	Од	Баянзүрх дүүрэг, 7-р хороо, Их тойруу-36
3	Хөх тэнгэрийн заяа ХХК	Доллар	Сонгинохайрхан дүүрэг, 19-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 28

-ooOoo-